



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 723

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн, нийт 19,500,000.00 (арван есөн сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгө (автомашин)-ийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 10,000,000.00 (арван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, цагдаагийн хурандаа Т.Сүхболд, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

123007033
35-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12-дугаар сарын 21 -ны өдрийн
143 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон, дахин үнэлсэн он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)		Хүлээн авах байгууллагын нэр
				Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Нийт үнэ (төгрөг)	
1	"Уаз-22069" 40-23 УБҮ /арлын дугаар 452190/	2011/2022	4,000,000.00	2	2,000,000.00	Хил хамгаалах ерөнхий газарт
2	"Уаз-22069" 40-32 УБҮ /арлын дугаар 374100В0452150/	2011/2022	3,500,000.00	2	2,000,000.00	
3	"Тоёота ланд круйзер-100" 34-21 УНН /арлын дугаар JTECJ09J505510929/	2008/2022	12,000,000.00	2	6,000,000.00	
Нийт дүн			19,500,000.00		10,000,000.00	
			(арван есөн сая таван зуун мянган)		(арван сая)	